

## Х.Чойбалсангийн эдийн засгийн үзэл санаа

Д.Төмөртоогоо

### Х.Чойбалсангийн эдийн засаг, нийгэм-улс төрийн үзэл санаа бүрэлдэн бий болсон нь

Хорлоогийн Чойбалсан бол монгол орны нийгэм - улс төрийн түүхнээ арилшгүй мөр үлдээж ухамсарт амьдралаа улс орныхоо хөгжил цэцэглэл, тусгаар тогтнолын төлөө зориулж сайн саар нэр дуулж явсан цэрэг, улс төр, нийгмийн томоохон зүтгэлтэн мөн. Түүний улс төр, нийгмийн үзэл санаа, тэр дотроо эдийн засгийн үзэл баримтлал нь аажмаар өөрчлөгдөж хувьсаж төгөлдөржин боловсорсоор ирсэн нь мэдээж хэрэг.

Манай хуучин түүхнээ Чойбалсанг эцэггүй, эхээрээ овоглож явдаг гэх авч судлаачдын лавшруулан тогтоосноор тийм биш, **Хорлоогийн Чойбалсан** маань **Жамцын Дугар** нэртэй хүү байж, хийдэд шавилуулахад нь сахилын нэр өгсөнөөр нэр солигдож, эцэг Жамц нь уул нутгийн хүн биш одоогийн Өвөрмонголын Дагуур нутгаас орж ирсэн, түүнийг нялх цагт эхээс нь салж нутагтаа буцаад хожим буцаж ирсэн боловч төдөлгүй өөд болсон тул өөрөө эхээрээ овоглож нэр овог нь бүрэн солигдсон ажээ.

Х. Чойбалсангийн үзэл санаа, баримтлал нь улс орны хөгжлийн хэм зэргэмж, дэлхий дахины байдал, өөрийнх нь мэдлэг боловсрол, оюуны хөгжлийн хэрээр аажмаар бүрэлдэн цогцолсон нэгэн иж бүрэн бөгөөд дотроо үгүйсгэл, зөрчилтэй, хувьсал хөгжилтэй юм. Энэ нь тэрбээр анхнаасаа нэгэн зорилго чиглэл, үе шаттайгаар системтэй мэдлэг олж авч чадаагүй, ерөнхийдөө боловсрол бага байсантай нь холбоотой байж болох юм. Тэр анх Сан бэйсийн хүрээ буюу бэйс Сансрайдоржийн хошууны гол хүрээнд шавилан сууж төвд үсэг нүдлэх төдий боловсрол олж авсан боловч түүнээ орхиод нийслэл хүрээнд оргон ирж энд тэнд хоноглон тохиолдлын орлогоор арай ядан амь зууж яваад аажимдаа тэр цагтаа боловсролтой гэгдэж байсан бичгийн түшмэл Догсомын Бодоогийн гэрт сууж бичиг заалгасан бололтой байдаг. Д.Бодоогийн нөлөөгөөр анх хувьсгалын хэрэгт оролцож эхэлсэн нь бодитой зүйл. Тэрбээр Бодоотой элэгсэг харилцаатай байж, гэрт очиж хонон өнжин ярилцаж уулзаж байсан бөгөөд Бодоог хэлмэгдүүлсэн үед түүнийг Бодоогийн хамсаатан гэж албан тушаал бууруулан, намын орлогч гишүүн болгож байсан явдал ч буй. Үүнийгээ Чойбалсан 1942 онд өөрийн бичсэн намтартаа огт дурсаагүй нь зүйн хэрэг билээ.

Төдөлгүй тэр цагийн Богд хаант Монгол улсын Гадаад яамны дэргэд байгуулагдаад байсан орос-монгол бага сургуульд суралцаж тэндээсээ багш нарынхаа дэмжлэгтэйгээр Хаант Орос улсын Эрхүү хотноо очиж бараг 3 жил суралцсан байна. Орос улсад самуун дэгдэж хувьсгал гарсны улмаас 1917 оны хоёрдугаар сарын хувьсгалын дараагаар [Октябрийн хувьсгалын дараа биш шүү. Д.Т.] монгол сурагчдаа татан авчрахад тэр буцаж ирэхдээ хэдүйнээ 22 нас хүрсэн боловч **улс төрийн хувьсгалт үзэл санаа** нь төдий л гүйцэд төлөвшөөгүй байсан бололтой. Бид нэгэн үе Чойбалсан, Сүхбаатар нар болон ардын хувьсгалын анхны

зүтгэлтэн нарыг хэзээний хувьсгалчид, тэр ч байтугай **социалист, коммунист үзэлтэй**, анхнаасаа монгол оронд коммунизм байгуулахаар зорьж байсан мэтээр хийрхэж байсан үе бий. Гэтэл монголын хувьсгалчдаас Хувьсгалт засаг тогтсон Орос оронд суралцаж байгаад ирсэн цорын ганц хүн болох Чойбалсан өөрөө бичсэн намтартаа *"Хаант засаг сөнөтүгэй"* гэсэн нэгэн том үсгээр бичсэн зарлал ба мөн түүний нэгэн адил бусад үзсэн зүйлсийг эс оруулбал бид үнэндээ оросын хувьсгалын тухай юу ч мэдэхгүй байсан болой" гэж тэмдэглэсэн байдаг.<sup>1</sup>

Тэгэхлээр монголын хувьсгалчид тэр дотроо Чойбалсангийн үзэл санаа, ялангуяа **хувьсгалч үзэл санаа** нь хэдийвээр Оросын хувьсгал, орос хувьсгалчдын нөлөө туссан нь үнэн боловч түүнийг нутагт нь дуудаж ирүүлсэнээс хойш эх орныхоо бодит нөхцөл байдлыг харж мэдэрч, харийн булаан эзлэгчдийн дарлал, доромжлолыг амсаж, тусгаар тогтнолоо эргүүлэн алдаж буйг харж мэдсэний үрээр "алдагдсан эрхээ эгүүлэн олохыг" хүссэн эрмэлзэлээс нь аяндаа аажмаар үүсэж бий болсон гэж үзүүштэй юм. Түүнээс биш Оросод байхдаа улаан хувьсгалч болж ирээд, хувьсгалч үзлээ нутагтаа дэлгэрүүлж хувьсгалт нууц бүлгэм байгуулан тэмцэх болсон биш болой. Тиймээс монголын хувьсгалчид, тэр дотроо гол удирдагч нь болсон Х. Чойбалсан ч өөрийн оронд социализм байгуулах зорилтыг анхнаасаа тавиагүй бөгөөд тэр талын мэдлэг ойлголтгүй байсан билээ. Харин тэдний гадаад түнш, зөвлөгч, туслагч, чиглүүлэгч нь болсон Коминтерн хийгээд Холбоот улсын зүгээс Монголын хувьсгалчид анхнаасаа өөрийн оронд тийм нийгэм байгуулах зорилготой байсан гэж сурталдаж ухуулж ойлгуулж амьдралд хэрэгжүүлэхийг чармайж байсан ажээ. 1928 онд Коминтерний төлөөлөгч Б. Шмераль МАХН төв хорооны хамтарсан хуралдаан дээр хэлсэн үгэндээ *"Нам анх үүссэн цагаасаа аваад монголын эдийн засгийг хөгжүүлэхдээ улс орноо капиталист шатыг алгасан социализмд хүргэх үзэл бодол баримталж иржээ"* гэсэн байдаг.<sup>2</sup>

Анх Чойбалсанд монголын бусад хувьсгалчдын нэгэн адил **капиталист бус хөгжлийн зам**, социализм, коммунизм байтугай ерөөсөө нийгмийн хөгжлийн үечлэл, формацын онолын талаарх ямар ч мэдлэг үзэл баримтлал байгаагүй нь мэдээж хэрэг. Тэд анхнаасаа огт марксист төдийгүй социал-демократ үзэлтэн ч байгаагүй нь ойлгомжтой. 1921 оны 12 дугаар сард Д. Сүхбаатар, С. Данзан хоёрыг Орос улсад явсан байх цагт Д. Бодоо, Д. Чагдаржав, Чойбалсан гурав Данзангийн үлдээсэн нэгэн зурвасын талаар ярилцан зөвлөлдөх үед Бодоогоос бусад хоёр нь **"Бүгд найрамдах засаг"** гэгч чухам юу болох тухайд огт ойлголтгүй байсан гэдэг.<sup>3</sup> Тэгээд Бодоо "Хаангүй бөгөөд сонголтыг хэрэглэх" засаг гэдэг тайлбарлаж хэлбээс Чагдаржав нь ихэд эгдүүцэн "...тэгвэл энэ Данзанг даруй албал зохих хүн болно" гэхэд Чойбалсан нь дэмжиж байсан гэхээс үзвэл тухайн цагт тэдний ухаанд хаангүй засаг гэгч огт багтахгүй байсан ажээ. Тэрбээр улс орноо харийн түрэмгийллээс ангижруулахыг хүссэн, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн олохыг мөрөөдсөн, түүнийгээ хэрэгжүүлэхэд наанадаж хань нөхдийн, цаанадаж харь орны дэм тус хэрэгтэйг ухаарч сэхээрсэн манай **үндэсний дэвшилт үзэлтний** нэг мөн. Тэд эхлээд бүлгэм, улмаар улс төрийн нам байгуулалцан Оросын хувьсгалчдаар дамжуулан Орос улсаас цэрэг, эдийн засгийн дэмжлэг олж эх орноо чөлөөлөх тэмцэлд амь биеэ зориулан тэмцэж ялалт, ялагдал үзэж, ял зэм сонсож зарим нь хэлмэгдэж, зарим нь хэлмэгдүүлж явсан нь түүх болон үлдсэн юм.

**"Ардын намын долоо"** гэж ном зохиолд мөнхөжсөн долоон хүнээс үнэн хэрэгтээ зөнгөөрөө насан өөд болсон хүн үгүй гэхэд хилс болохгүй биз ээ. Бодоо, Чагдаржав хоёрыг 1922 онд, Сүхбаатарыг 1923 онд, Данзанг 1924 онд, Лосол, Догсом хоёрыг 1939 онд үгүй болгосон байдаг. Тэдний дотроос цаашид улс орныхоо төрийг толгойлж насан эцэс хүртлээ ажилласан нь гагцхүү Х.Чойбалсан билээ. Бодоо, Чагдаржав хоёрыг буруутган тушаалаас нь бууруулах үед Чойбалсан Орос улсад яваад ирээгүй байсан боловч чухамд цааш харуулах үед нь буцаж ирсэн байв. Мөн Сүхбаатар үгүй болох үед тэрбээр зүүн хязгаарт явж байсан билээ. Харин Дарьзавын Лосол, Дансранбилэгийн Догсом хоёрыг хэлмэгдүүлэгч нь чухамхүү Чойбалсан гэж үзүүштэй болдог. Х. Чойбалсан 1939 оноос эхлэн 1952 онд насан эцэслэх хүртлээ Ерөнхий сайд байсан бөлгөө. Сүхбаатар, Чойбалсан хоёрыг өвчнөөр насан эцэслэсэн гэх боловч аль нь ч элдэв эргэлзээ төрүүлж магадгүй байдлаар өнгөрсөн гэдэг.

<sup>1</sup> Бат - Очир. Л. Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй...). УБ. 1996. 197-р тал.

<sup>2</sup> Коминтерн ба Монгол. УБ. 1996. 234-р тал.

<sup>3</sup> Бат - Очир. Л. Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй...). УБ. 1996. 24-р тал.

Чойбалсанд эхлээд эх орноо чөлөөлөх, харийн түрэмгийлэгчдийг хөөн гаргах, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн мандуулахад чиглэсэн үндэсний **эх оронч үзэл** баримтлал төлөвшин бий болсон нь маргаангүй. Энэ үзэл нь тухайн цагт цөөн тооны хувьсгалчдын эрмэлзэл төдий биш тэр цагийн нийт монголчуудын хүсэл зорилго болсон хэрэг байсан юм. Тэрхүү үзэл баримтлал нь хожим үеийнхний боддог шиг улаан хувьсгалч, "цэвэр марксист-ленинист" үзэл огт бус болой. Х.Чойбалсангийн үндэсний эрх чөлөөг эрмэлзэх, улс төр-эдийн засгийн тусгаар тогтнолыг олохын төлөөх үзэл нь эхэндээ **ардчилсан үзэл ч бус** байсан бөгөөд **бурхны шашны** баримтлалыг дагасан **үзэл** байжээ. Монголын хувьсгалчдад, тэр дундаа өсөх насандаа хийдэд шавилж асан Чойбалсанд анхан үедээ **шашингүйн үзэл, ангийн тэмцлийн** тухай ойлголт байсангүй. Тэд нийслэл хүрээнээс нууцаар гарч Зөвлөлт Орос улсаас тусламж гуйхаар сэм мордохдоо ламаас өдөр судраа асууж, Майдар бурханд мөргөж байсан байдаг.

Монголын хувьсгалчдын үзэл баримтлалыг анхлан тусгасан баримт бичгүүдэд шашин лам нарыг устгах гэсэн санаа огт үгүй харин ч хамгийн анх хоёр нууц бүлгэм нэгдэж Монгол ардын нам гэдэг хувьсгалт байгууллага байгуулсан 1920 оны 6 сарын 25-ны өдрийн хурлаар баталсан **"Намын хүмүүсийн дагаж явах тангарагийн бичиг"**-тээ **"Гадаад Монголын Ардын намын зорилт нь: Шашин, үндсэнд харшлах харгис дайсныг цэвэрлэж, алдагдсан эрхийг эгүүлэн аваад, төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж, үндэс язгуурыг алдагдуулахгүй сахих ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж, ядуу доод ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнө үүрд сахиж, дарлах дарлагдахын зовлонгүй аж төрөхийг чухал болгоно"** гэж бичсэн буй. Тийнхүү бурхны шашны суртлаас ангид байгаагүй нь баттай зүйл юм. Тэр үед байтугай нэлээд хожуу буюу 1929 онд Коминтерний Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын хуралдаан дээр Монгол Ардын хувьсгалт намын тухайд **"Буддын шажин энэ намын жинхэнэ үзэл суртал болж байгаа юм"** гэж тодорхойлж **"...буддизмын өөдөөс марксизмыг сөргүүлэн тавих ёстой"** гэж хэлж байсан байдаг билээ.<sup>4</sup>

Монголын хувьсгалчдын анхны зүтгэлтнүүдийн доторхи нэлээд боловсролтой, хос ёсны буюу төр, шашны аль аль талын мэдлэгтэй орос, монгол, төвд, манж хэлтэй лам Д. Бодоо насан ахмадын хувьд 1921 оны тавдугаар сарын 28-нд Чойбалсанг "Баруун замын тусгай ангийн цэргийн яам"-ны захирагч бөгөөд Ардын журамт цэргийн Дэд жанжны тушаал хүлээн явах зуурт түүнд илгээсэн захиа даалгавартаа **"...Хоосон хөөс мэт эд хөрөнгийг...онцлон үзэхийг тэвчихийг"** зөвлөсөн байдаг. Үүнээс үзэхэд Бодоо өөрөө **эд баялагийг хоосон хөөс мэт** гэж үзэх бурхны шашны сурталтай байна. Зөвхөн Бодоо ч биш ийм үзэлтэй хүн тэдний дотор нэг бус байсан байхыг үгүйсгэх аргагүй. Анх тэд өөрсдийн эд хөрөнгийг үрж зарж бэл болгож Орос улс тийш явцгаасан гэх бөгөөд Сүхбаатар гэрээ зарж, нэмж өр тавьж явсанаа төлж дуусалгүй өөд болсон байж ч магадгүй. Чойбалсан нэлээд хожим хашаа байшингаа зарж өрөө дарсан гэх мэдээ байдаг.

Ер нь Ардын намын анхны хүмүүс олонхи нь өөрийн эд хөрөнгө амь биеийг үл хайрлан зорьсон хэрэгтээ зүтгэхийг эрхэм болгох тангарагтай байснаас бус төр нийгмийн хямралт зурвас үеийг ашиглан хөрөнгөжиж баяжихыг хичээсэнгүй нь **нэгд**, улс үндэстнийхээ эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэх чин санаа, хувьсгалч үзлээс гадна, **хоёрт**, бурхны шашны үзэл санаа буюу эд хөрөнгийг зуурдын хоосон зүйлс гэж үзэх явдалтай ч холбоотой байж болох юм. Тэдний дотроос Д. Сүхбаатар, Х. Чойбалсан нар уулаас ядуу доорд гаралтайн дээр үзэл баримтлалд нь ч эдийг эрхэмлэх сэтгэл төдийлэн хүчжээгүй байсан гэж үзүүштэй бөгөөд тэдний өмч хөрөнгө гэгч зүйл үндсэндээ алга байжээ. Харин Солийн Данзан, Чагдаржав мэт нь тэр үедээ арай ч хоосон бус байжээ.

Монголын хувьсгалчдын нийгэм-улстөрийн үзэл баримтлал төлөвшихөд Оросын хувьсгалчид, Орос оронд гарсан хувьсгалын үзэл санаа гойд нөлөөлсөн нь мэдээж бөгөөд тэдний үзэл бодлоо илэрхийлэн бичсэн баримт бичгүүдийн дотор аажмаар **үндэсний дэвшилт үзлийн** дээр хувьсгалч үзэл санаа, мөнхүү харийн мөлжлөгийг эсэргүүцсэн төдийгүй ангийн дарлалыг шүүмжилсэн эдийн засгийн агуулга бүхүй утга санаа гарах болсон байна. Монгол Ардын Намын анхны долоон хүн гэгдэх төлөөлөгчид нууцаар Орос оронд очсон хойноо бичсэн **"Гадаад Монголын Ардын намын төлөөлөгч нараас Орос улсын Зөвлөлт засгийн газар**

<sup>4</sup> Коминтерн ба Монгол. УБ. 1996. 272, 273-р тал.

**лугаа хэлэлцэх зүйлүүдийг тэмдэглэсэн нь**“ гэдэг баримт бичигт 1920 оны наймдугаар сарын 25-наа бичихдээ *“Монголын засгийн газрын сангийн зүйлийг Хятад булаасан учраа эдүгээ ойрын цагт шинэ засаг ба Ардын намын хооронд зарцуулах мөнгө чухал хэрэгтэй тул зургаа, долоон сая лан мөнгийг Зөвлөлт засгийн газраас урьдчилан туслахыг гуйна. Монголын засгийн газрын сан ба автономийг устгаснаас хойшид түрээс гааль тэргүүтнээс хураасан мөнгө хөрөнгө зүйлүүд ба цэргийн хорооны газраас хураасан буу зэвсэг, сум, цахилгаан мэдээ тэргүүтэн хуучин байсан, шинэ үйлдсэн бүгдийг Гадаад Монголын шинэ байгуулах Засгийн газар бүрмөсөн эгүүлэн олгох тухай хэрэгт Орос улсын Зөвлөлт засгийн газраас тусламж үзүүлэхийг гуйна”* гэж тэмдэглэсэн байдаг.<sup>5</sup> Өөрөөр хэлбэл, түр зуурт хэрэглэх мөнгө хөрөнгө хүсэмжлэхийн дээр монгол улсын тусгаар тогтнолыг эвдлээд эрхшээлдээ оруулсан Хятад улсаас эрх чөлөө тусгаар тогтнолоо эгүүлэн авах цагт тэднээс нэхэх хөрөнгийн тухай тун тодорхой өгүүлсэн байна. Үүнээс дөрөв хоногийн дараа бичсэн **“Дорно зүгийн олон ард улс лугаа холбогдох хорооны монгол-төвдийн хэлтэст толилуулах ину”** гэдэг баримт бичигт *“Гадаад Монголын ардын байгуулсан харилцан туслалцах хоршоо хэмээн байгуулж Орос улсын ардын байгуулсан харилцан туслалцах хоршоо лугаа холбоо үйлдээд Гадаад Монголын мал ба түүхий эдийг Орос улсад нэвтэлгэж оросын харилцан туслалцах хоршооноос монгол газар элдэв зүйлийн эд боловсруулах чухал хэрэгтэй үйлдвэрийн хороодыг монголын ардын хоршооны нэр дээр байгуулан өгч байхыг хүснэ”* гэж бичжээ.

Энд монголын мал, түүхий эдийг орос улсад экспортлох, бас элдэв зүйлийг үйлдвэрлэх үйлдвэрийн газар байгуулахад туслахыг хүсэмжилсэн байна. Энэ нь монголын хувьсгалчдын сэтгэхүйд үндэсний үйлдвэрлэл бий болгох, аж үйлдвэрийн газар гэгчийг эх орондоо байгуулах санаа төрж байсны баримт болой. Гэхдээ тэдний төсөөлж байснаар “үйлдвэрийн хороод” буюу аж үйлдвэрийн газар нь юуны өмнө мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэр биш байсан бололтой юм. Орос оронд байсан аж үйлдвэрийн газрын төрхөөр л ойлгон “элдэв зүйлийн эд боловсруулах үйлдвэр” гэж бичиж байсан хэрэг биз ээ. Тэд харийн булаан эзлэгчдийн дарлалыг устгах, эрх чөлөө, тусгаар тогтнолоо, олохыг эрхэм болгохын дээр улс орныхоо эдийн засгийг сэргээх, гадаад худалдаа, аж үйлдвэрийг үүсгэн хөгжүүлэх санал эрмэлзэлтэй байжээ.

Монголын хувьсгалчдын дотор Богд Хаант Монгол улсын Улсын доод хуралд оролцож төрийн бодлого, цэрэг, улс төр, эдийн засгийн тулгамдсан олон асуудлыг хэлэлцэж явсан Догсом, Дугаржав, Сүхбаатар зэрэг бичиг цэргийн түшмэлүүд, Бодоо зэрэг бичгийн сэхээтэн, тэр цагт байгуулсан боловч төлөвшлийг олоогүй харилцан туслалцах хоршооны тэргүүн Чагдаржав, бас гаалийн хорооны түшмэл Данзан зэрэг тухайн цагтаа улс орны эдийн засгийн байдлын талаар тодорхой төсөөлөлтэй хүмүүс багталцаж байсан нь эдийн засгийн бодлогоо тодорхойлоход нь дөхөм болж байсан буй заа.

Энэ үед тэдний бичиж байсан зүйлсийн дотор хамжлагат ёсыг халах, дарлагч ангийн эдийн засгийн хүч чадлыг бууруулах, феодалын хөрөнгийг хураах, гадаадын капиталыг шахан гаргах, сүм хийдийн эдийн засгийн хүчийг сулруулах, хамтралжуулах гэх мэт үгс огтхон ч байхгүй. Өөрөөр хэлбэл тэдэнд улс орныхоо эдийн засгийг үндсээр нь өөрчлөн социализм байгуулах төлөвлөгөө байсангүй. Тэд ерөөсөө улс төрийн эдийн засгийн ухааны аливаа мэдлэггүй байсан нь илэрхий бөлгөө. Эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулахыг эрмэлзэн зүтгэх явцдаа, дарлал мөлжлөгийн аливаа хэлбэрийг арилгах, нийгмийн тэгш бус байдлыг халах, гадаадын шунахай худалдаачдын савраас улс орныхоо эдийн засгийг аврах, үндэсний гол баялаг болон мал аж ахуйгаа өөд татах, чөлөөт бөгөөд тэгш худалдаа харилцааг хөгжүүлэх, үндэсний аж үйлдвэрийн газар бий болгох зэрэг эдийн засгийн наад захын хэрэгцээг ухаарч эхэлснээ тэд эдийн засгийн зорилтдоо тусгаж байжээ.

Энэ санаагаа тэд Орос улсад оросын хувьсгалчдын дэмжлэгтэйгээр 1920 оны гуравдугаар сараас эхлэн гаргаж байсан **“Монголын үнэн”** гэгч сонинны анхны дугааруудад нэн тодорхой томъёолсон байдаг. Тухайлбал: *“..хуучин хуурмаг, харгис үзэл, уг залгамжлан суух хаад ноёд ба баячуудыг засгийн эрхээс зайлуулан холдуулж, эрдэмтэй бөгөөд улс ардад итгэлтэй хүмүүстэйгээ хамжиж ард нийтийн амар жаргал олох чөлөөт байдлыг найруулан зохиож, хан ван ноёд баячуудын хомголзох шунахайрахаас үүсэгч цэрэг дайныг бүрмөсөн*

<sup>5</sup> Монгол ардын хувьсгалт намын тогтоол шийдвэр, баримт бичгүүд. №1, УБ.1981. 10, 11-р тал.

огоорч, нэгэн хүн нөгөөг боолчлон дарлах ба нэгэн улс нөгөө улсыг дарлах ...байдлыг устган арилгахыг зүтгэн оролдож амуй" гэж "Монгол улсад ямар засаг хэрэгтэй вэ" гэдэг өгүүлэлд бичсэн байв.

Энэ өгүүлэлд "угсаа залгамжлах хаад ноёдыг засгийн эрхнээс зайлуулан холдуулах" гэж нэн тодорхой бичсэн нь урьд өмнө бичигдээгүй байсан санаа юм. Бас зөвхөн зайлуулан холдуулах гэснээс бус тэднийг анги хэмээн устгах, хэлмэгдүүлэх тухай санаа огт үгүй бөлгөө. Тэрчлэн "Монгол улсын боловсрон мандах явдал тус" гэдэг өгүүлэлд "...улсын эрдэм боловсрол ургааш явсангүй, газар дэлхийн ашиг олз ба эд таваарын үйлдвэр нэвтэрсэнгүй, улсын ба ардын сан хөрөнгө арвижуулагдсангүй байсан тул автономит монгол улс нь гадаадын хөрөнгөлөгүүд ялангуяа хятад, оросын харгис засгууд ба баячуудын гарт бүрмөсөн оржээ" (онцлов, Д.Т.) хэмээн хуучин төр засгийн эдийн засгийн бодлого явуулгыг шүүмжлэн үнэн хэрэгтэй эдийн засгийн тусгаар тогтнолоо алдсан байна гэж дүгнэсэн байна. Анх уул нь тэд "алдагдсан эрхээ эгүүлэн авах" зорилготой байсан улс шүү дээ.

Тэдний улс төр-эдийн засгийн зорилго ийнхүү улам тодорхой болж, өргөжин гүнзгийрч ангич, намч шинжтэй болсоор байжээ. "Монголын шинэ ардын засаг байгуулах үндсэн журам" гэдэг өгүүлэлд гадаад зарим орнуудын парламентын сонгуульт засаглал дахь булхай, хөрөнгөлөг этгээдүүд хэрхэн засгийн эрхийг сонгуулиар эзэлдэг тухай, өөрийн оронд ийм баячуулыг сонгодог засаг байгуулахгүй "ардын засгийг зөвлөн бүтээх хэдэн хүмүүст бариулах" тухай нэн тодорхой өгүүлсэн ахул "Монгол улс сэрэмжилтүгэй" гэдэг өгүүлэлд "Монгол улс нь гаашуун зовлонгоос гэтэлж амгалан жаргалангаар оршин ашиг үйлдвэр, аж байдал нь боловсрон дэлгэрэх болно" хэмээн ирээдүйгээ тодорхойлсон байдаг. Улмаар Ардын хувьсгалын ялалтын дараа 1921 оны гуравдугаар сарын 26-нд хэвлэгдсэн "Монголын үнэн" сонины 5 дугаарт хэвлэгдсэн "Монгол улсын ардын эрхт засаг тогтсоны тус" гэдэг өгүүлэлд "Ардын нам ба Ардын засгийн урьд зарласан ёс журмаар айл гүрэн улс нар лугаа эвээр найрамдаж, мандсан Монголын улс төрийг ардын эрх чөлөөг гол болгон зохиож, бат нотоор бэхжүүлж, олон түмэндээ амгалан жаргалан олгомуй хэмээн бид нар гүнээ итгэмүй" хэмээжээ.

Харин "Монголын үнэн" сониныг хэвлэх, тэнд хэвлэгдсэн өгүүлүүдийн эхийг зохиох хэрэгт Чойбалсан шууд оролцсон гэж үзэхэд бэрх. Нэгд, уг сонин монгол нутагт хэвлэгдэж байгаагүй, хоёрт, уг сонины дугаарууд ид гарч байх үед 1921 оны хоёрдугаар сарын хорьдоос гуравдугаар сарын аравдыг хүртэл Чойбалсан Нийслэл хүрээ, Вангийн хүрээ зэрэг газраар нутгийн гүнд явж байсан байдаг. Гэхдээ тэнд өгүүлсэн үзэл баримтлалаас ангид тэрс үзэлтэй биш байсан нь мэдээж билээ.

Цаашдаа хувьсгалын зорилт гүнзгийрэх, авах арга хэмжээ, тавих зорилт тодрохын хэрээр монголын хувьсгалчдын эдийн засгийн программ улам тодорхой болж аажимдаа улс орны эдийн засгийг бүхэлд нь өөрчлөн байгуулах их зорилгод чиглэх болсон нь мэдээж юм. Монголын хувьсгалчдын эдийн засгийн зорилтыг ихэд нарийвчлан улам тодруулж ардын нам, ардын төрийн цаашдын бодлогын үндэс болгосон баримт бичиг бол 1923 оны 4 дүгээр сарын 23-нд намын төв хороогоор хэлэлцэж "ёсоор болгон" улмаар 1923 оны наймдугаар сард Монгол Ардын Намын II их хурлаар сайшаан баталсан "Эдийн засгийн үндсэн бодлого" гэдэг арван найман зүйлт баримт бичиг юм. Түүнийг Монгол Ардын намын Төв хороо тусгай комисс гаргаж боловсруулуулсан гэдэг<sup>6</sup>. Энэ баримт бичигт улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэх үндсэн бодлогыг маш цэгцтэй тодорхойлсон байдаг юм.

Түүнд мөн өмч хөрөнгө хураах, нийгэмчлэх гэх мэт зүйл үгүй. Харин "албан татварыг хураахдаа эрхтэн дархтан, лам хар гэхгүй зөвхөн хөрөнгийн зузаан, нимгэнийг харгалзуулж, чадал хөрөнгө зузаадах тутам татвар гувчуурыг улмаар өсгөн хураавал зохино" гэсэн буй. Арван найман зүйл нэлээд том энэ баримт бичигт машин, телефон, банк гэсэн гурван европ үг нэгээс гурван удаа орсноос өөр ер харь үггүй, бичгийн найрлага, үг хэллэг нь уламжлалт монгол бичгийн хэлний эх зохиох барилаар зохиогдсон байх учраас түүнийг гадны зөвлөх, ялангуяа орос сургагч оролцоогүй монголчууд дангаараа боловсруулсан гэж баттай хэлж болох баримт бичиг болой. Харин түүнийг боловсруулахад Чойбалсан оролцсон гэж бодохгүй байна. Учир нь түүнийг 1922 оны арван хоёрдугаар сард "хязгаарын ба нутгийн цэргийг шалган байцаах дэд

<sup>6</sup> Социалист эдийн засгийн түүх. УБ.1985. 19-р тал.

жанжины орон тоо бий болгож ажиллуулахаар томилсон тушаалыг хүлээн аемагц Зүүн гурван хязгаарын цэргийг шалган байцаах ажлаар явсан"<sup>7</sup> гэж бичсэн байдаг юм. Чойбалсан энэ тушаалд найман сар ажиллаад 1923 оны наймдугаар сард Засгийн газрын шийдвэрээр Зөвлөлт улсад цэргийн сургуульд суралцахаар одож бараг нэг жил болоод намын III их хурал нээгдэхийн өмнөхөн 1924 оны зун эрүүл мэндийн шалтгаанаар эргэж ирсэн байна. Товчоор хэлбэл тэр үед Чойбалсан нам төрийн эдийн засгийн бодлогоос харьцангуй хол хөндий алба хашиж байсан буюу их төлөв эзгүй байсан ажээ.

**Эдийн засгийн үндсэн бодлого** гэдэг энэ баримт бичигт улс орны мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, аж үйлдвэр, ашигт малтмал, ой мод, гадаад дотоод худалдаа гааль татвар, банк санхүү, сургууль соёл, эрүүлийг хамгаалах хүн ам, ажиллах хүчин гэх зэргээр аливаа бүхнийг товчлон багтаасан байдаг.

Монголын хувьсгалчдын эдийн засгийн бодлого нь цаашид улам тодорхой болж өргөжин гүнзгийрч, Ардын засгийн явуулж эхэлсэн арга хэмжээнүүдээр хэрэгжин төр, засгийн шийдвэрүүдээр боловсорч, баталгаажин төгөлдөржсөөр байв. Ингэж аажмаар бүрэлдэн бий болсон улс төр, эдийн засгийн үзэл баримтлалын нэгэн бүрдэл нь улс орны хөгжлийн хэтийн төлөв стратегийн асуудал болно. Энэ асуудлыг 1924 онд хуралдсан МАХН-ын III их хурал болон Улсын анхдугаар их хурлаас шийдвэрлэж үндсэн чиг шугамыг тодорхойлон тогтжээ. Ийм шийдвэр гаргахад монголын нийгмийн тухайн байдал, дэлхий дахинд бүрэлдэн бий болсон хүчний харьцаа зэрэг бодит байдлаас гадна тэр үед манайд ажиллаж байсан сургагч нараараа дамжуулан Зөвлөлт Орос мөн Коминтерний зүгээс ихээхэн чармайлт тавьжээ. Хөгжлийн энэ замыг сонгон авах асуудал нь элдэв маргаан зөрөлдөөнгүй, амар хялбар байсан бус. Өнөө бид хөгжлийн капиталист бус замыг МАХН-ын III их хурлаас улс орны хөгжлийн чиг шугам болгож сонгон тогтсон хэмээн үздэг боловч нарийн шинжлэн үзүүштэй эгзэг бий гэж үздэг судлаачид ч байдаг.<sup>8</sup>

Энэ их хурлын явц дундуур санал зөрөлдөөнөөс үүдэн гарсан маргаант асуудлыг улам лавшруулж хурцатгаж С. Данзанг буудаж хороосон байдаг. С. Данзанг буруутган баривчлуулах хэрэгт оролцож байсан нь мэдэгдэх боловч хороох ажилд шууд гар бие оролцсон хүмүүсийн дотор Х. Чойбалсангийн нэр гардаггүй харин дараа нь цэрэг ардын дунд ухуулга хийх С. Данзанг хороосноо зөвтгөх ажилд түүний оролцоо нэлээд идэвхтэй байсан бололтой юм. Чухамхүү хөгжлийн замыг сонгон авах асуудал дээр Чойбалсан аль талд нь зогсож байсан нь тодорхой мэдэгдэхгүй ч Данзанг буруутгаж байсныг нь үзвээс тэрбээр хөрөнгөтний замаар замнахгүй гэсэн эрмэлзэлтэй байсан буй заа. Тэгээд ч уг их хурлын бэлтгэл ажилд төдий л гүнзгий оролцоогүй болов уу гэхээр хоног тулгаж шахам гадаадаас ирсэн байдаг билээ. Ардын намын анхны долоо гэгдэгч долоон хүний нэг, анхны хувьсгалт нууц бүлгэмийн нэгийн үүсгэн байгуулагч, Намын Төв хорооны дарга С. Данзан (1883-1924) энэ их хурлын үед тэрхүү капиталист бус замын асуудлаар бусдаасаа өөр байр суурь эзэлж өөр санал гаргаж сургагч, зөвлөхүүдтэйгээ зөрж маргалдаж байсан ажээ. Уул зөрөлдөөнийг дэвэргэж хурцатган түүнийг шүүхгүйгээр буудаж хороосон байдаг юм. Үнэн хэрэгтээ энэ үйл явдлын цаана үзэл баримтлалын зөрөлдөөн гол шалтгаан болж байсан эсэх нь тодорхойгүй. Энэ асуудлыг тусгайлан судлаж тодруулбаас зохих боловч бидний судалгааны хүрээнээс халих юм.

Судлаачдын үздэгээр Данзан нь **нэгд**, Монголын хувьсгалын ололтыг үгүйсгэж хувьсгалт ололтоос ухран хуучин феодалын ёсонд эгүүлэн оруулах гэсэн хуучны үзэлтэн биш, **хоёрт**, Монгол улсын тусгаар тогтнолыг үгүйсгэж аль нэг харь орны хараат болгох гэсэн зориудын далд санаатай биш, **гуравт**, анхлан хувьсгалт нууц байгууллага байгуулахаас эхлэн Оросын хувьсгалчдаар дамжуулан Зөвлөлт Орос улстай холбоо найрамдал тогтоох ажилд зүтгэж тусламж дэмжлэг авч үр шимийг нь үзсэний хувьд Монгол-Зөвлөлтийн найрамдлыг эсэргүүцэгч биш, **дөрөвт**, харин хөгжлийн ямар замыг сонгон авах асуудал дээр бусдаасаа арай өөр байр суурьтай байж энгийн капиталист харилцаа хөгжүүлэхийг санаархагч үндэсний жижиг өмчтөн дундчуудын төлөөлөгч байжээ. Тэр өөрөө урьд нь гаалийн хорооны түшмэл, Сангийн яамны түрээсний түшмэл гэх мэт албатай байсан нь түүнд эрхбиш энгийн худалдааг хөгжүүлэхгүйгээр, гадаад хөрөнгөлөг улсуудтай арилжаа худалдаа хийхгүйгээр улс орноо өөд нь

<sup>7</sup> Бат - Очир. Л. Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй...). УБ.1996. 26-р тал

<sup>8</sup> Даш. Д. Солийн Данзан. УБ.,1990. 23-р тал.

татахад бэрх гэсэн сэтгэгдэл төрүүлсэн байж болгох талтай юм. Түүнээс гадна Данзан өөрөө хэрдээ хөрөнгөжиж, гадаадын пүүснийхэнтэй сүлбэлдэж баяжихын төлөө хөөцөлдөх болсон байдаг. Энэ бүхэн нь түүний хөрөнгөт бус зам гэдэг ойлголтоос зайлсхийх харин ч хөрөнгөт замаар явах сан гэсэн эрмэлзэл төрүүлэхэд түлхэц өгсөн байж болох юм. Харин Чойбалсангийн хувьд бол цаашид өсгөх сөн арвижуулах юмсан гэх хөрөнгө байсангүй. Ер нь Чойбалсан насан туршдаа хөрөнгө хогшил хураасан зүйлгүй бөлгөө.

Хөгжлийн капиталист бус замыг сонгон авсан болон Зөвлөлт орос улстай бат найрамдалтай болсон асуудал нь монголын хувьсгалчдын анхны зорилтоос ухарсан няцсан хэрэг огтхон ч биш бөгөөд чухамдаа энэ зам нь монголын хувьсгалчдын язгуур зорилго хийгээд нийт монголчуудын өнийн хүсэл эрмэлзэлтэй үндсэн шугамаараа нийцэж байсныг үгүйсгэж болохгүй. Тухайн түүхэн цаг үед үндэсний тусгаар тогтнолоо алдахгүйн тулд тулж түших хамгийн дөт дөхөм түшиг нь Орос орон байсан гэдгийг огт үгүйгэж болохгүй.

Тийнхүү Монгол улс хөгжлийн капиталист бус замаар замнаж улмаар нийгэм журамд дэвшин орох зорилт бүхүй орон болсноор монголын хувьсгалчдын зорилт шинэ шатанд орлоо. Монголын засаг, төрийн удирдагчид өөрийн оронд нийгмийн шинэ байгууллыг бий болгох зорилт тавьж хувьсгалт өөрчлөлт, тэр дундаа эдийн засгийн өөрчлөлтийг улмаар нийгэм журамд шилжих хандлагад чиглүүлэх болсон байна. Энэ хэрэгт Монголын хувьсгалчдын нэгэн Х. Чойбалсан гар бие оролцох болов. Энэ замаар замнах үйлс хөнгөн хялбар байсангүй. Элдэв бэрхшээл саад тэр дундаа ядуу буурай орны тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, хамгаалах улс төр, дипломат бодлогоос эхлэн харийн дайсны цэргийн түрэмгийллийг няцаах хүртэл хүнд бэрхийг туулахын ялдамд эдийн засаг, санхүүгийн гачигдал тулгарч байсан нь гарцаагүй боловч түүнээс илүүгээр нам, төрийн удирдагчдын үзэл саналын зөрөлдөөн, намын доторхи **"баруун, зүүн"** хэлбэрэл гэх мэт гуйвалт дайвалт ихээхэн бэрхшээл учруулжээ. Судлаачдын тэмдэглэсэнээр Х.Чойбалсан баруунтан гэгдэж шүүмжлэгдэж байсан боловч харин зүүнтэн болж явсангүй ажээ.

Түүний зүүний нугалаа завхрал гэгчид оролцоогүйн шалтгааныг Л.Бат-Очир тайлбарлахдаа Чойбалсан өөрөө зүүний бодлого явуулгад эргэлзсэн байдлаар хандахын дээр гэргий нь гүн их шүтлэгтэй, гэр орноор нь Богдын шадар хүмүүс холхиж байдаг зэргээс нь болж хэт хувьсгалч зүүнтэн нар түүнд итгэлтэй хандаагүйтэй холбож үзсэн байдаг.<sup>9</sup> Тэр хожим нь зүүнтний улс төр, эдийн засгийн бодлого явуулгыг нэлээд ултай шүүмжилсэн байдаг. Ажваас бодлого явуулгын зөрүү байсан гэмээр ажээ.

Тийнхүү улс орны хөгжлийн бодит нөхцөл, тухайн цаг үеийн дэлхий дахины улс төрийн байдал зэрэг дотоод гадаад хүчин зүйлийн шууд, дам нөлөөгөөр монголын хувьсгалчдын тэр дундаа Х. Чойбалсангийн үзэл санаа нь аажмаар хөгжлийн капиталист бус замын зорилтууд лугаа гулсан оржээ. Тэрээр мэдлэг боловсрол нимгэн боловч түүнээ мэдрэн цаашид суралцахыг чармайж, өргөдөл хүсэлт тавьж байсан боловч цаг төрийн байдал ийм боломж олгосонгүй. Харин боловсрол багатай гээд богино ухаантай байсангүй, үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөгөө ямар үнээр боловч олж авч, хамгаалан тэмцэх холч бодлого, эрмэлзэлтэй байжээ гэж үзүүштэй байдаг юм. Түүний үйлс бүтээлд сайн, сайн бус зүйлс сүлжилдсэн байх боловч амьдралынх нь туршид нэвт тууштай мэдрэгдэх нэгэн судал бий бөгөөд энэ нь үндэсний эрх чөлөө, төр, улсын тусгаар тогтнолын төлөө гэх сэтгэл зүтгэл мөн.

Монголын шилдэг сэхээтнүүд үнэхээр нэн **"ховордсон"**, үе улиран гэрийн сургууль, гарын багшаар төрийн бодлогын өнийн уламжлалыг өвлөж авдаг эртний язгууртай хуучин "феодал" нарыг зориуд **"цөөрүүлсэн"** үед Чойбалсан манай төрийн бодлогод чухал байр суурьтай албан тушаал эзэлж байсан бөлгөө. Чухамдаа тэрээр монголын төрийг барьж байх цагтаа холч гүн бодлого боловсруулах зорилго, эрмэлзэл, зүтгэл, сэтгэл өвөрлөсөн байжээ гэхэд тийм боловсрол, мэдлэг туршлага, тулах онол, туслах нөхдөөр гачигдаж аливаад харийн сургагч зөвлөгчдийн амыг хардаг байсан гэж үзүүштэй ч гол баримтлал нь зөв бөгөөд холч гүн байсан гэж үзэхээр байдаг. Тэрбээр хэдүй алдаж онож янз бүрээр оролдож, оролдуулж явсан ч төр улсаа туурга тусгаар улс байлгаж, улам цэцэглүүлэн хөгжүүлэхийн төлөө чин сэтгэлээр зүтгэж явснаас бус нэгэн биеийн жаргал хөөж, хөрөнгө зоорь хурааж, "сан идэж, салхи залгиж"

<sup>9</sup> Бат - Очир. Л. Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй...). УБ.1996. 29-р тал.

явахыг гол болгож байгаагүй гэмээр билээ. Х. Чойбалсангийн тухай олон үг өгүүлбэр бий боловч америкийн монголч О. Латтимор бичсэнийг бид "эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй" гэдэг монгол хэллэгт нэн ойр дүгнэлт гэж үзэх нь үнэнд дөхөм юм. Латтимор, Чойбалсангийн тухайд "Тэрээр улс төрийн бодлогыг хортойгоор завхруулахын эсрэг үзэлтэй хүн. Гэхдээ аль нэгэн үзэл суртлыг санаачлагч буюу номлол баримтлалыг шинэчлэгчийн дүр үзүүлж байсан гэх иш баримт олдоогүй" гэжээ.<sup>10</sup> Түүний Кремлийн хананд хэзээ ч баригдаж байгаагүй хувийн зан чанар чухал ач холбогдолтой санагддаг<sup>11</sup> гэж Латтимор бичсэн байх атал нэлээд хүмүүс түүнийг харин Кремлийн төлөөний хүн байсан мэтээр үздэг явдал ч бий. Түүний үлдээсэн мөрд цагаан бараан аль аль нь бий боловч зөв бурууг нь бид өдгөө шүүх ёсгүй билээ.

#### Ашигласан ном зохиол

1. Агваан. Ш. Х. Чойбалсан ба дотоод явдлын яам. УБ. 1991.
2. Бат - Очир, Л. Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй...) УБ. 1996.
3. Даш. Д. Солийн Данзан. УБ., 1990.
4. Жагварал. Н. Амьдрал, үйл, үзэл баримтлал. УБ. 2000. Хэвлүүлсэн. Ц. Отхон.
5. Коминтерн ба Монгол. УБ. 1996.
6. Латтимор. О. Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ. 1994.
7. Монгол ардын хувьсгалт намын тогтоол шийдвэр, баримт бичгүүд 1 УБ. 1981.
8. Ринчин. М, Ичинноров. С, Дүйнхэржав. Г. Хорлоогийн Чойбалсангийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, байр суурийн асуудалд. "Засгийн газрын мэдээ" сонин. 1991 оны 5 дугаар сар. №16., 17, 18.
9. Социалист эдийн засгийн түүх. УБ. 1985.
10. Чойбалсан. Х, Лосол. Д, Догсом. Д. Монголын үндэсний хувьсгалын үүсч байгуулагдсан товч түүх. УБ. 1979.
11. Ширэндэв. Б. Далайн давалгаанаар. УБ., 1993.

---

<sup>10</sup> Латтимор. О. Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ. 1994. 102-р тал.

<sup>11</sup> Латтимор. О. Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ. 1994. 102-р тал.